



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 18 өдөр

Дугаар А/27

Мандалговь

Хуулийн хэрэгжилтийг хангуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "л" дэх заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. 2021 оныг "Бизнес эрхлэгчдийг дэмжих жил" болгосонтой холбогдуулан эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх, ажилтан албан хаагчдын эрх ашгийг хангах зорилгоор аймгийн бүх төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудын ажилчдын цалин хөлсийг 2021 оны 1 дүгээр сараас эхлэн сард хоёр удаа олгож хэвшүүлэхийг Төсвийн шууд захирагч нарт даалгасугай.

Хоёр. Тус захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү төрийн сангийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Энхтайван), Мэргэжлийн хяналтын газрын дарга (Ш.Төрбат), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

Гурав. Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагуудыг ажилчин албан хаагчдынхаа цалин хөлсийг сард хоёр удаа олгож хэвшүүлэхийг байгууллагын удирдлагуудад уриалсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481213056